

**“УЛААНБААТАР ЛИФТ” НӨҮГ-ЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ
ШАЛГАЛТ ЯВУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН**

2025 оны 06 сарын 13

Улаанбаатар хот

№	Төлөвлөсөн ажил	Хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА, ДОТООД АЖЛЫН ҮР ДҮНГ САЙЖРУУЛАХАД ЧИГЛЭСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТ			
1.1	Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, холбогдох газарт тайлагнах;	<p>Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, холбогдох газарт тайлагнан ажилласан байна.</p> <p>- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 1 арга хэмжээ тусгагдсан ба хэрэгжилт 50 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус хөтөлбөрийн 1.2.20-д “Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат, дээвэр, фасад, инженерийн шугам сүлжээг өргөтгөн шинэчилж иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэн арга хэмжээний хэрэгжилт 50 хувийн гүйцэтгэлтэй байна.</p>	50%
1.2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтүүдийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, холбогдох газарт тайлагнах;	<p>Монгол Улсын Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан нийт 20 заалтыг хяналтад авсан ба хэрэгжилт 98 хувийн гүйцэтгэлтэй байна. Тайлан мэдээг I, II улирлын байдлаар гаргаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь хүргүүлж тайлагнасан байна.</p>	98%
1.3	Байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн	<p>Байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн үнэлгээний судалгааг гэрээт 66 Аж ахуйн нэгж, байгууллага, Сууц өмчлөгчдийн холбооны дарга, ажилчдаас байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг 2025 оны 01 дүгээр сарын 06-10, 2025 оны 04 дүгээр сарын 14-18-ны өдрүүдэд тус тус хийсэн. Судалгаанаас үзэхэд засвар, техник үйлчилгээ үзүүлэх явцад ажилчид ёс зүйн</p>	100%

	<p>үнэлгээний судалгаа авах ажлыг зохион байгуулж, тайлан үр дүнг удирдлагад танилцуулах;</p>	<p>зөрчил гаргасан тохиолдол байхгүй. Механикуудын ажлын ур чадварыг сайн гэж дүгнэсэн байна.</p> <p>Хэрэглэгчдээс ирүүлсэн санал хүсэлтийг нэгтгэж үзэхэд байгууллага бие даан өргөн хэрэглээний сэлбэг материалтай болох, 24 цагаар дуудлага хүлээн авч, үйлчилгээ үзүүлэх гэсэн саналууд дийлэнх хувийг эзэлсэн байна.</p> <p>Тус саналын холбогдох арга хэмжээг авч, үр дүнг нэгтгэн байгууллагын удирдлагад танилцуулан ажилласан байна.</p>	
1.4	<p>2025 оны байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, холбогдох газарт тайлагнах;</p>	<p>Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 4 зорилт, 43 арга хэмжээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрээр хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа ба хэрэгжилт 98 хувийн гүйцэтгэлтэй байна. Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сар улирал бүр удирдах дээд байгууллагад тайлагнан ажилласан байна.</p>	98%
1.5	<p>Нийслэлийн Засаг дарга, Хотын Ерөнхий менежер болон Газрын даргын шуурхай зөвлөгөөнөөр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнах;</p>	<p>Нийслэлийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөр нийт 27 үүрэг даалгавар, Газрын даргын шуурхай зөвлөгөөн 6 удаа болсон бөгөөд өгөгдсөн үүрэг даалгавар тус бүрийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, биелэлтийг тухай бүр тайлагнасан байна. Дундаж хэрэгжилт 98 хувьтай байна.</p>	98%
1.6	<p>Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, http://erp.ulaanbaatar.mn системийн</p>	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн www.erp.ulaanbaatar.mn системийн edoc программд байгууллагад ирсэн албан бичгийг хүлээн авч байгууллагын "Албан хэрэг хөтлөлтийн журам"-ын дагуу ангилан бүртгэж, холбогдох ажилтанд шилжүүлэн ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 232 албан бичиг бүртгэгдсэнээс 32 хариутай албан бичиг хүлээн авсан ба тухай бүр хугацаанд нь хариу өгч шийдвэрлэж ажилласан.</p>	100%

	<p>ашиглалтад хяналт тавих;</p>	<p>Нийт явуулсан албан бичиг 99 байна.</p> <p>Албан бичгийн шийдвэрлэлтийн байдалд болон хариутай албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавин ажилласан байна.</p> <p>- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн систем erp.ulaanbaatar.mn нэгдсэн сайтаар хоёрдугаар улирлын байдлаар нийт 7 өргөдөл гомдол, хүсэлт ирсэн байна. Нийт ААНБ, СӨХ-ны үйл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдол ирснийг тухай бүр шуурхай шийдвэрлэн ажилласан бөгөөд иргэд аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулж хуулийн хугацаанд нийслэлээс дэвшүүлсэн зорилтот түвшинд шийдвэрлэсэн байна.</p>	
1.7	<p>Архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалт, баримт бичгийн стандартын хэрэгжилтэнд хяналт тавих;</p>	<p>2025 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг байгууллагын нийт албан хаагчдаас санал авч байгууллагын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01 дүгээр хурлаар хэлэлцэж нийт 85 хадгаламжийн нэгж баталсан.</p> <p>- 2025 оны 02 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд ажилтнуудаас баримт бичиг хүлээн авах графикийн дагуу байгууллагын 2024 оны үйл ажиллагааны явцад үүсэж хөтлөгдсөн баримт бичгүүдээр ХХНЖ-ын дагуу хэрэг бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан. Нийт 156 хадгаламжийн нэгж үүссэнээс 70 жил хадгалах-5, түр хадгалах-77, байнга хадгалах-59, байгууллагын байнга хадгалах хадгаламжийн нэгж-4, архивын хувийн хэрэгт-11 баримтыг тус тус ангилан төрөлжүүлж хэрэг бүрдүүлсэн.</p> <p>- Нийслэлийн архивын газрын Archive Edoc программд 2024 онд үүсэж хөтлөгдсөн Захирамжлалын 82 баримт бичгийг агуулга тодорхойлон шивж бүртгэлд оруулсан. Захирамжлалын нийт 82 баримтыг http://erp.ulaanbaatar.mn нэгдсэн сайтын ArchiveEdoc системд агуулга тодорхойлон үндсэн үйл ажиллагааны асуудлаар гаргасан даргын А тушаал 26, Хүний нөөцийн асуудлаар гаргасан даргын Б тушаал 56-г шивж оруулсан байна.</p>	100%
1.8	<p>МУЗГ, НЗД-ын "Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай" албан даалгаврууд, тогтоолын хэрэгжилтийг</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ", газрын даргын 2025 оны А/14 дүгээр тушаалаар албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинэчлэн баталсан ба цахим хуудас болон мэдээллийн самбартаа тогтмол байршуулан ажиллааандаа</p>	100%

	<p>хангаж, байгууллагын дотоод журам, албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, эд хөрөнгийн бүртгэл, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж зөрчил, дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг зохион байгуулах;</p>	<p>хэрэгжүүлэн, мөрдөж, зөрчил, дутагдалгүй ажиллаж байна.</p> <p>Байгууллагад сахилга, дэг журам, дотоод хяналтыг чангатгах, хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд сахих, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн (erp.ulaanbaatar.mn цахим хуудас болон цаасаар) өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэж байх, ажилчдын цаг ашиглалтыг ERP-ийн цаг бүртгэлийн хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулж, ажлын цагийг бүрэн, үр дүнтэй ашиглах, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох зэрэг ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Түүнчлэн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн сайжруулж ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар болон галт, хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглосон заалтуудыг нэмж тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	
1.9	<p>Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулж, удирдлагыг мэдээллээр хангах;</p>	<p>Байгууллагын цахим хуудсаараа дамжуулан байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг цаг алдалгүй түгээн хүргэж байна. Түүнчлэн Нийслэлийн эрх зүйн нэгдсэн сан болох www.ublegal.mn цахим хуудсанд байгууллагаас гаргасан захирамжлалын баримт бичгийг тухай бүр байршуулан цахим санг эрхэлж хөтлөх тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Байгууллага нь нийслэлийн төсвөөс санхүүждэг тул бүх төлбөр тооцоо нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн хяналтан дор хийгдэж байна. Нийслэлийн Өмчийн харилцааны газартай байгуулсан контракт гэрээний дагуу эд хогшил худалдан авах тохиолдолд саналаа өгч Нийслэлийн Өмчийн харилцааны газрын хурлаар шийдвэрлэгддэг ба мөн 10 сая төгрөгнөөс дээш гэрээ хэлцлийг Нийслэлийн Өмчийн харилцааны газраас зөвшөөрөл авч байгуулан ажилласан.</p> <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын http://ublifit.ub.gov.mn/ цахим хуудсанд тогтмол баяжуулалтыг хийж, иргэд, олон нийтийн оролцоог ханган ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар цаг үеийн болон бусад 282 мэдээлэл байршуулсан байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар заалтад заасан Нээлттэй мэдээллүүдийг тогтмол шинэчилж байна.</p>	100%

		Хэрэгжилтийн мэдээг хугацаанд нь Нийслэлийн Засаг даргын Тамгын тайлагнан ажилласан байна.	
ХОЁР. ТӨСӨВ, САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ			
2.1	Байгууллагын үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, эд хогшлын тооллого, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавих;	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 09 дүгээр тогтоолын дагуу хийгдэх "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг тооллого"-ыг байгууллагын хэмжээнд хагас, бүтэн жилээр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	-
ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ЯВУУЛАХ ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ			
3.1	Лифтийн механикуудын гэрээт аж ахуйн нэгж, байгууллага, СӨХ-ны лифтэнд засвар, техник үйлчилгээ хийсэн байдалд хяналт тавих;	Цахилгаан шатанд засвар, техник үйлчилгээ хийж гүйцэтгэх гэрээгээр 66 Аж ахуйн нэгж, байгууллага, Сууц өмчлөгчдийн холбоо 191 цахилгаан шатанд сар бүр графикийн дагуу техник үйлчилгээ хийж байна. Эхний хагас жилийн байдлаар 66 Аж ахуйн нэгж, байгууллага, Сууц өмчлөгчдийн холбоодын нийт давхардсан тоогоор 1225 цахилгаан шатанд засвар, техник үйлчилгээг технологийн дагуу чанартай хийж гүйцэтгэн, графикийг сар бүр гаргаж, ашиглалтын найдвартай ажиллагаа болон аюулгүй байдлыг хангаж ажилласан. Мөн хугацаанд гэрээгээр хариуцан ажилладаг 187 эвдрэл гэмтлийн дуудлагыг хүлээн авч, цахилгаан шатыг засварлаж, хэвийн ажиллагаанд оруулж, иргэд оршин суугчдын аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлж ажилласан.	100%
3.2	"UB ENGINEERING" төслийн мэдээллийн сангийн дата бүрдүүлэх, мэдээллийн сан байгуулах;	"UB engineering"-ийн Нийслэлийн цахилгаан шатны нэгдсэн хяналтын системийн мэдээллийн санд баяжуулалт хийх талаарх видео хичээл, цахим гарын авлага боловсруулж байгууллын цахим хуудсанд 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр байршуулсан. - 80 ААНБ, СӨХ-дын удирдлагуудад тус системд баяжуулалт хийх талаарх мэдээллийг цахимаар болон утсаар өгч ажилласан. - 2025 оны эхний хагас жилийн байдлаар https://ub-engineering.gov.mn/ мэдээллийн санд 2979 цахилгаан шатны мэдээлэл бүртгэлтэй байна.	100%

3.3	Лифтийн техникийн ээлжит магадлалын актын бичиг баримтын бүрдэлд хяналт тавих;	Эхний хагас жилийн байдлаар олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд 43 аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийн дагуу гэрээт болон гэрээт бус 223 лифтэнд техникийн ээлжит магадлалын ажлыг хийж гүйцэтгэн, Ерөнхий инженерт танилцуулж, лифтний аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна. Магадлалын актын хувийг цахилгаан шат эзэмшигч байгууллагад хүргүүлж ажилласан.	100%
3.4	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуй /ХАБЭА/ хяналтыг үе шаттайгаар зохион байгуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;	<p>-Газрын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.</p> <p>Лифтний механикуудад өдөр тутмын ажлын байран дахь аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ХАБЭА-н давтан зааварчилгааг улиралд 1 удаа өгч ХАБЭА-н журмыг мөрдүүлэн аваар осолгүй ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд инженер техникийн хэсгийн албан хаагчдыг ажлын гутал, бээлий зэрэг шаардлагатай хөдөлмөр хамгааллын хувцсаар бүрэн хангаж ажилласан. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн нөхцөлийг хангахад шаардлагатай нэг удаагийн маск болон анхан шатны тусламжийн хэрэгсэл, өдөр тутмын ажилд шаардлагатай багаж хэрэгслийг шинэчлэн хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөлийг хангаж ажилласан.</p> <p>Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвд байгууллагын нийт 16 ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд 2025 оны 02 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд хамруулсан байна.</p>	90%
3.5	Инженер, механикуудын хувцас, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангуулж ажиллана.	Нийт инженер, механикуудыг хөдөлмөр хамгааллын нормын хувцас, багаж хэрэгслийг хэрхэн зөв зохистой хэрэглэж байгаад хяналт тавьж, зуны ажлын хувцас, бээлий, маск зэрэг шаардлагатай хөдөлмөр хамгааллын хувцсаар хангаж, бүрэн бүтэн байдлыг хангуулан ажиллаж байна.	100%
Дундаж хувь:			97%

ХЯНАСАН:
ДАРГА

Д.ГАН-ЭРДЭНЭ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
ХҮНИЙ НӨӨЦЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ц.ӨСӨХЖАРГАЛ